



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 322

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Түвшин оргил” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Баяр нь өөрийн эзэмшлийн нэг бүр нь 4,000 төгрөгийн үнэ бүхий 5,000 ширхэг, нийт 20'000'000.00 /хорин сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг “Хэйва финанс” ХХК-д шилжүүлсэн тул холбогдох өөрчлөлтийг хавсралтад заасны дагуу бүртгэсүгэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Түвшин оргил” ХХК /Б.Баяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 19 дүгээр сарын 23-ний  
өдрийн 22 дугаар тогтоолын хавсралт

**“ТҮВШИН ОРГИЛ” ХХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ**

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 5,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 5,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Б.Баяр /УЖ65043058/	4,000	20,000,000.00	100%	(4,000)	-	20,000,000.00	-	-	-
2	“Хэйва финанс” ХХК /6451136/	-	-	-	4,000	-	-	4,000	20,000,000.00	100%
	<b>Нийт</b>	<b>4,000</b>	<b>20,000,000.00</b>	<b>100%</b>	-	20,000,000.00	20,000,000.00	<b>4,000</b>	<b>20,000,000.00</b>	<b>100%</b>